# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр Дугаар А/123 Арвайхээр сум

**Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай.**

Монгол улсын Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19 3.2, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7дугаар зүйлийн 7.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Агаарийн бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн 2023 оны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, сумдын салбар комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Аймгийн ажлын хэсгийн дарга (И.Доржсүрэн)-д даалгах нь:

1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах ажлыг оновчтой зохион байгуулж, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах.

2.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах ажлыг саатуулсан, зайлсхийсэн буруутай албан тушаалтан, иргэнд хуулийн хариуцлага тооцож ажиллах.

3.Тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, жолоочийн даатгалд даатгуулаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар төрийн холбогдох байгууллагуудад үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3.Сумын Засаг дарга нар болон сумын салбар ажлын хэсгийн ахлагч нарт даалгах нь:

1.Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөрийн аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт бүрэн шилжүүлж, татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

2.Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклийг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

3.Сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харьяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2023 оны ...03... дугаар
сарын ...13...-ны өдрийн ...А/125... дугаар
захирамжийн хавсралт

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЙМГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Эрдэнэсувд (Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Татварын хэлтсийн дарга)

Ц.Алтан-Эрдэнэ ( Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга)

Б.Мөнхбат (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын, хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)

Өвөрхангай аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгалын байгууллагуудын төлөөлөл

Б.Цэндсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын, хэлтсийн Улсын байцаагч мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Амартүвшин (Аймгийн Автотээврийн төвийн дарга)

Аймгийн Засаг даргын 2023 оны...05...дугаар
сарын ...13......-ны өдрийн ...А/223... дугаар
захирамжийн хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ,
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ СУМДЫН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Сумын хэсгийн төлөөлөгч болон цагдаагийн ажилтан

Татварын байцаагч

Багийн Засаг дарга нар

Аймгийн Засаг даргын 2023 оны ..03..
дугаар сарын ..13..-ны өдрийн А/123 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

# Сумдад ажиллах хуваарь

| № | Сумдын нэрс | Сар өдөр | Ажиллах Хоног | Ажлын бүрэлдэхүүн |
|---|---|---|---|---|
| 1 | Өвөрхангай Арвайхээр | 01 дүгээр сарын 05-аас 4 дүгээр сарын 08 | *** | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 2 | Бүрд | 04 дүгээр сарын 11,12 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 3 | Есөн зүйл | 04 дүгээр сарын 13,14 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 4 | Өлзийт | 04 дүгээр сарын 15,16 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 5 | Баян-Өндөр | 04 дүгээр сарын 17-19 | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 6 | Сант | 04 дүгээр сарын 20,21 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 7 | Баянгол | 04 дүгээр сарын 22-24 | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 8 | Төгрөг | 04 дүгээр сарын 25,26 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 9 | Гучин-Ус | 04 дүгээр сарын 27,28 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 10 | Богд | 04 дүгээр сарын 29-нөөс 05-р дугаар 01-нийг дуустал | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 11 | Баруунбаян-Улаан | 05 дугаар сарын 02,03 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 12 | Баянтээг баг | 05 дугаар сарын 04,05 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 13 | Нарийнтээл | 05 дугаар сарын 06,07 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 14 | Хайрхандулаан | 05 дугаар сарын 08-10 | 3 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | Таргт | 05 дугаар сарын 11,12 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 16 | Жаргалант баг | 05 дугаар сарын 13,14 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 17 | Уянга | 05 дугаар сарын 15-18 | 4 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс |
| 18 | Зүүнбаян-Улаан | 05 дугаар сарын 26,27 | 2 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 19 | Батөлзий | 05 дугаар сарын 28,29,30,31<br>06 дугаар сарын 02,03 | 6 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 20 | Хужирт | 06 дугаар сарын 04-08 | 5 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 21 | Хархорин | 06 дугаар сарын 09-20 | 12 | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |
| 22 | Арвайхээр | 06 дугаар сарын 22-ээс<br>12 дугаар сарын 25 дуустал | **** | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв, Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар дахь Замын цагдаагийн тасаг, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс, Даатгалын байгууллагууд |